



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2015 оны 11 дүгээр  
сарын 2-ны өдөр

Дугаар 433

Улаанбаатар  
хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 8.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын 2012 оны 98 дугаар тогтоолын 16 дугаар хавсралтаар баталсан “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг дор дурдсанаар өөрчилсүгэй:

Гишүүд:


- Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
- Санхүүгийн зохицуулах хорооны гишүүн (зөвшилцсөнөөр);
- Аж үйлдвэрийн яамны Хөнгөн үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга;
- Зам, тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
- Гаалийн ерөнхий газрын дэд дарга;
- Стандартчилал, хэмжил зүйн газрын дэд дарга;
- Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга (тохиролцсоноор);
- Санхүүгийн зах зээлийн холбооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын ноос, ноолуурын холбооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Монголын тариаланчид, гурил үйлдвэрлэгчдийн холбооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
- Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгчдийн мэргэшсэн брокерүүдийн нэгдсэн холбооны удирдах зөвлөлийн дарга (тохиролцсоноор);

-Монголын махны холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);

-Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны зөвлөх (тохиролцсоноор).

Нарийн бичгийн дарга

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын хөдөө аж ахуйн биржийн асуудал хариуцсан мэргэжилтэн.



Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хүнс, хөдөө аж ахуйн сайд

Р.БУРМАА